



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/35

Цагаан-Уул сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэх Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд Удирдлагын академи Төрийн албаны сургуульд 90 хувиас дээш үнэлгээтэй 2 албан хаагчийг 50 хувийн хөнгөлөлт олгож мэргэшүүлэх ажлын техникийн тодорхойлолт боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: Ч.Оюунчимэг (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)


Гишүүд: Б.Ичинхорлоо (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: З.Аззаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д даалгасугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/